

Зарим хүнд ердийн болон урт хугацааны даатгалын
актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 39.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын 2.1, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын орлогч дарга Б.Мөнхбаатар, ахлах мэргэжилтэн П.Цэрэндэжид, мэргэжилтэн З.Батболд нарт ердийн болон урт хугацааны, “Нэйшнл лайф” ХХК-ийн ажилтан Б.Балжинноров, П.Мөнхжаргал нарт урт хугацааны даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх тус тус олгосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ